

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Рашаант сумын эрүүл мэндийн төвийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/009/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsGol@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/186  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН РАШААНТ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.САРУУЛ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Рашаант сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Рашаант сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,198,682.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 982,422.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 216,260.7 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 34,783.4 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчлийг илрүүлснээс 32,684.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 600.0 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 1,498.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Рашаант сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 84.5 хувьтай дүгнэсэн байна.

670002010

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>148,728,624.43</b>	<b>386,722,636.55</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>29,713,067.63</b>	<b>33,147,662.73</b>
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>29,713,067.63</b>	<b>33,147,662.73</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>29,713,067.63</b>	<b>33,147,662.73</b>
31211	Төрийн сангийн харилцах	29,713,067.63	33,147,662.73
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>17,547,878.00</b>	<b>216,260,715.07</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	17,547,878.00	216,260,715.07
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>101,467,678.80</b>	<b>137,314,258.75</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>24,751,168.06</b>	<b>39,263,117.11</b>
35130	Эм боох материал	24,751,168.06	39,263,117.11
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>76,716,510.74</b>	<b>98,051,141.64</b>
35410	Бичиг хэргийн материал	806,000.00	2,176,050.00
35460	Хүнсний материал	1,137,207.50	3,186,407.50
35470	Бусад хангамжийн материал	74,773,303.24	92,688,684.14
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>446,176,002.88</b>	<b>574,531,099.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>446,176,002.88</b>	<b>574,531,099.95</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>434,186,169.68</b>	<b>562,677,099.95</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	354,952,789.00	368,379,129.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,994,993.60	-58,660,644.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42,284,000.00	86,484,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,783,277.82	-6,444,500.07
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	154,020,126.46	199,822,662.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,791,364.88	-59,616,104.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,736,812.00	38,084,682.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,112,921.28	-9,579,207.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,000,000.00	14,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,125,000.20	-9,792,916.91
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>11,989,833.20</b>	<b>11,854,000.00</b>
39301	Программ хангамж	407,500.00	407,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-271,666.80	-407,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,854,000.00	11,854,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>594,904,627.31</b>	<b>961,253,736.50</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>28,772,461.58</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,676,324.22
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	12,689,937.36
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>00.00</b>	<b>14,406,200.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	14,406,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>594,904,627.31</b>	<b>932,481,274.92</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>594,904,627.31</b>	<b>932,481,274.92</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	243,416,874.00	243,416,874.00
51101	Өмч: - төрийн		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>90,050,417.65</b>	<b>429,370,725.26</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	90,050,417.65	91,794,077.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	337,576,647.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,437,335.66	259,693,675.66
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>594,904,627.31</b>	<b>961,253,736.50</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>826,349,731.92</b>	<b>1,412,227,587.92</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>35,439,748.93</b>	<b>191,451,921.10</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	35,439,748.93	191,451,921.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	191,451,921.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	46,664,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	35,439,748.93	144,787,921.10
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>790,909,982.99</b>	<b>1,220,775,666.82</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,026,000.00	39,640,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	39,026,000.00	39,640,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	751,883,982.99	1,181,134,966.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	751,883,982.99	1,181,134,966.82
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>870,588,135.60</b>	<b>1,074,069,720.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>870,588,135.60</b>	<b>1,074,069,720.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	870,588,135.60	1,027,545,720.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	544,164,005.32	690,438,734.14
210101	Үндсэн цалин	299,330,224.48	399,395,473.90
210102	Нэмэгдэл	190,618,483.94	231,962,939.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,405,811.39	8,396,000.00
210104	Урамшуулал	49,809,485.51	50,684,320.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,545,525.66	88,770,625.23
210201	Тэтгэврийн даатгал	46,655,765.20	61,378,231.81
210202	Тэтгэмжийн даатгал	5,473,443.46	6,699,634.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,406,609.22	3,322,336.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,091,755.16	3,333,143.88
210205	Эрүүл мэндийн даатгал	10,917,952.62	14,037,278.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,740,000.00	36,408,387.36
210301	Гэрэл, цахилгаан	2,875,844.36	3,049,740.96
210302	Түлш, халаалт	25,504,155.64	30,958,646.40
210303	Цэвэр, бохир ус	2,360,000.00	2,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	54,862,619.50	44,734,550.00
210401	Бичиг хэрэг	2,846,750.00	5,218,700.00
210402	Тээвэр, шатахуун	25,714,550.00	29,021,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,865,000.00	3,179,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,917,571.00	7,314,400.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	93,322,205.37	113,658,608.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,150,277.87	98,367,408.65
210502	Хоол, хүнс	16,171,927.50	15,291,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,653,238.00	6,410,000.00
210604	Урсгал засвар	12,868,000.00	6,410,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,396,000.00	3,474,000.00
210702	Дотоод албан томилолт	2,396,000.00	3,474,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,888,950.00	4,333,072.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,926,900.00	3,078,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	1,152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,600.00	55,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	37,200.00	12,000.00
210807	Газрын төлбөр	120,000.00	35,562.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	50,015,591.75	39,317,742.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,751,400.00	1,896,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,264,191.75	37,421,742.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	46,524,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	46,524,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	46,524,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>-44,238,403.68</b>	<b>338,157,867.61</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	581,220.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	581,220.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	00.00	-581,220.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>-44,238,403.68</b>	<b>337,576,647.61</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	0.00	(581,220.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(44,238,403.68)</b>	<b>337,951,292.07</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>773,362,104.99</b>	<b>1,068,726,829.75</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>46,664,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	46,664,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	0.00	46,664,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	46,664,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>773,362,104.99</b>	<b>1,022,062,829.75</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	39,026,000.00	39,640,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,026,000.00	39,640,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	734,336,104.99	982,422,129.75
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	734,336,104.99	982,422,129.75
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>783,178,490.98</b>	<b>1,042,963,334.65</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>783,178,490.98</b>	<b>1,042,963,334.65</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>783,178,490.98</b>	<b>996,439,334.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	544,164,005.32	690,424,552.96
210101	Үндсэн цалин	299,330,224.48	396,881,292.72
210102	Нэмэгдэл	190,618,483.94	231,962,939.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,405,811.39	8,396,000.00
210104	Урамшуулал	49,809,485.51	53,184,320.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,545,525.66	87,108,482.19
210201	Тэтгэврийн даатгал	46,655,765.20	60,114,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,473,443.46	6,550,995.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,406,609.22	3,197,487.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,091,755.16	3,308,199.19
210205	Эрүүл мэндийн даатгал	10,917,952.62	13,937,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,740,000.00	31,540,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,875,844.36	3,049,740.96
210302	Түлш, халаалт	25,504,155.64	26,090,959.04
210303	Цэвэр, бохир ус	2,360,000.00	2,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,673,650.00	49,876,550.00
210401	Бичиг хэрэг	2,850,000.00	4,313,200.00

210402	Тээвэр, шатахуун	24,944,550.00	29,021,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,760,000.00	3,016,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,020,000.00	6,462,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,099,100.00	7,062,800.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>71,802,710.00</b>	<b>96,142,577.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	56,352,410.00	73,092,077.50
210502	Хоол, хүнс	11,080,800.00	17,340,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,369,500.00	5,710,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,868,000.00</b>	<b>25,294,400.00</b>
210602	Тавилга	0.00	1,993,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	3,950,800.00
210604	Урсгал засвар	12,868,000.00	19,350,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,396,000.00</b>	<b>3,474,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,396,000.00	3,474,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,885,700.00</b>	<b>6,487,072.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,926,900.00	3,750,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200,000.00	480,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,600.00	55,510.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	37,200.00	12,000.00
210807	Газрын төлбөр	120,000.00	35,562.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	990,000.00	2,154,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,102,900.00</b>	<b>6,091,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,102,900.00	6,091,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>46,524,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>46,524,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	46,524,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(9,816,385.99)</b>	<b>25,763,495.10</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,500,000.00</b>	<b>22,328,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,500,000.00</b>	<b>22,328,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,500,000.00</b>	<b>22,328,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,500,000.00	22,328,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(13,500,000.00)</b>	<b>(22,328,900.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(23,316,385.99)</b>	<b>3,434,595.10</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>53,029,453.62</b>	<b>29,713,067.63</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>29,713,067.63</b>	<b>33,147,662.73</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	243,416,874.00	261,437,335.66	134,288,821.33	639,143,030.99
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,238,403.68	-44,238,403.68

<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>243,416,874.00</b>	<b>261,437,335.66</b>	<b>90,050,417.65</b>	594,904,627.31
<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>243,416,874.00</b>	<b>261,437,335.66</b>	<b>90,050,417.65</b>	594,904,627.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,743,660.00	1,743,660.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>243,416,874.00</b>	<b>261,437,335.66</b>	<b>91,794,077.65</b>	596,648,287.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,743,660.00	00.00	-1,743,660.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	337,576,647.61	337,576,647.61
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>243,416,874.00</b>	<b>259,693,675.66</b>	<b>429,370,725.26</b>	932,481,274.92

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

### Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,105,284,100.00</b>	<b>1,025,651,534.65</b>	<b>92.80</b>	<b>79,632,565.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,105,284,100.00</b>	<b>1,025,651,534.65</b>	<b>92.80</b>	<b>79,632,565.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,017,646,100.00</b>	<b>979,127,534.65</b>	<b>96.21</b>	<b>38,518,565.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>697,249,500.00</b>	<b>690,424,552.96</b>	<b>99.02</b>	<b>6,824,947.04</b>
210101	Үндсэн цалин	418,818,600.00	396,881,292.72	94.76	21,937,307.28
210102	Нэмэгдэл	215,473,500.00	231,962,939.88	107.65	(16,489,439.88)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,600,000.00	8,396,000.00	87.46	1,204,000.00
210104	Урамшуулал	53,357,400.00	53,184,320.36	99.68	173,079.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>87,108,500.00</b>	<b>87,108,482.19</b>	<b>100.00</b>	<b>17.81</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,515,600.00	60,114,400.00	101.01	(598,800.00)
210202	Тэтгэмжийн даатгал	6,898,200.00	6,550,995.55	94.97	347,204.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,449,100.00	3,197,487.45	92.70	251,612.55
210204	Ажилгүйдлийн даатгал	3,449,100.00	3,308,199.19	95.91	140,900.81
210205	Эрүүл мэндийн даатгал	13,796,500.00	13,937,400.00	101.02	(140,900.00)
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>51,708,600.00</b>	<b>49,876,550.00</b>	<b>96.46</b>	<b>1,832,050.00</b>
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	4,313,200.00	100.10	(4,500.00)
210402	Тээвэр, шатахуун	30,659,200.00	29,021,850.00	94.66	1,637,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,016,100.00	3,016,100.00	100.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,462,600.00	6,462,600.00	100.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,262,000.00	7,062,800.00	97.26	199,200.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>96,485,400.00</b>	<b>96,142,577.50</b>	<b>99.64</b>	<b>342,822.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,144,800.00	73,092,077.50	99.93	52,722.50
210502	Хоол, хүнс	17,340,400.00	17,340,400.00	100.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,200.00	5,710,100.00	95.17	290,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>39,135,600.00</b>	<b>38,423,300.00</b>	<b>98.18</b>	<b>712,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,888,900.00	9,888,900.00	100.00	0.00
210602	Тавилга	13,333,600.00	13,333,600.00	100.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,663,100.00	3,950,800.00	84.72	712,300.00
210604	Урсгал засвар	11,250,000.00	11,250,000.00	100.00	0.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>3,500,000.00</b>	<b>3,474,000.00</b>	<b>99.26</b>	<b>26,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	3,474,000.00	99.26	26,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,658,500.00</b>	<b>6,487,072.00</b>	<b>20.49</b>	<b>25,171,428.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,750,000.00	3,750,000.00	13.04	25,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	480,000.00	100.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	66,000.00	0.00	0.00	66,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,600.00	55,510.00	99.84	90.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,900.00	12,000.00	36.47	20,900.00
210807	Газрын төлбөр	120,000.00	35,562.00	29.64	84,438.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,154,000.00	2,154,000.00	100.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,800,000.00</b>	<b>7,191,000.00</b>	<b>66.58</b>	<b>3,609,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,800,000.00	7,191,000.00	66.58	3,609,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,638,000.00</b>	<b>46,524,000.00</b>	<b>53.09</b>	<b>41,114,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>87,638,000.00</b>	<b>46,524,000.00</b>	<b>53.09</b>	<b>41,114,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	87,638,000.00	46,524,000.00	53.09	41,114,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,105,389,100.00</b>	<b>1,029,086,129.75</b>	<b>93.10</b>	<b>76,302,970.25</b>
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>978,508,200.00</b>	<b>982,422,129.75</b>	<b>100.40</b>	<b>(3,913,929.75)</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	978,508,200.00	982,422,129.75	100.40	(3,913,929.75)
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>126,880,900.00</b>	<b>46,664,000.00</b>	<b>36.78</b>	<b>80,216,900.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	97,168,000.00	46,664,000.00	48.02	50,504,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	29,712,900.00	0.00		29,712,900.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	0.00	29,713,067.63		(29,713,067.63)
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	33,147,662.73		-33,147,662.73

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>39,640,700.00</b>	<b>39,640,700.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>39,640,700.00</b>	<b>39,640,700.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>39,640,700.00</b>	<b>39,640,700.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,540,700.00</b>	<b>31,540,700.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,240,000.00	3,049,740.96	94.13	190,259.04
210302	Түлш, халаалт	25,900,700.00	26,090,959.04	100.73	(190,259.04)
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,400,000.00	100.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,100,000.00</b>	<b>8,100,000.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	8,100,000.00	8,100,000.00	100.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>39,640,700.00</b>	<b>39,640,700.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>39,640,700.00</b>	<b>39,640,700.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	39,640,700.00	39,640,700.00	100.00	0.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 34,783.4 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчлийг илрүүлснээс 32,684.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 600.0 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгч, 1,498.6 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

#### 3.1 Залруулсан алдаа

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний хэсэг дэх урьд оны үлдэгдлээс санхүүжих 29,712.9 мянган төгрөгийг орхигдуулж, эх үүсвэр болон зардлын дүн тэнцээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төсвийн гүйцэтгэлийн эх үүсвэрийг зөв болгож залруулга хийсэн.
- Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн болон зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байсныг аудитын явцад нөхөж бэлтгэсэн.
- Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвөөс авсан 2,971.9 мянган төгрөгийн вакциныг давхардуулан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт "үнэн зөв байх;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,098.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 13,929.4 мянган төгрөгөөс 11,830.8 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

#### 3.2 Албан шаардлага

- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 24,836.1 мянган төгрөгөөр давсан дүнгээр худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Бараа материалын үлдэгдэлд бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн 446.6 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.
- Рашаант сумын Засаг даргын 2024 оны А/78 дугаар захирамжаар тус эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саруулын албан тушаалын жишиг цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоосноос 1,052.1 мянган төгрөгийг илүү

тооцож олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”, Эрүүл мэндийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 29.1-т “Эрүүл мэндийн ажилтны цалингийн тусгай сүлжээний доод жишгийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэж заасантай тус тус нийцэхгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан хаагчдийн цалинг тогтоохдоо хүчин төгөлдөр мөрдөж буй цалингийн сүлжээг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

#### **2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, эмийн зардлыг оруулалгүй орхигдуулсан, тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 48 дугаар зүйлийн 48.2.1 “Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;” Сангийн сайдын 2023 оны А/250 тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.11 “Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын

10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна.” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлант оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг төлөвлөх, өөрчлөлт орсон тухай бүрд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулах.

**3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

Илрүүлэлт:

2024 онд 1,241,871.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 60,736.6 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны програм, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж,..” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

**4. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардлаас сум байгуулагдсаны 100 жилийн ойг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ажилтнуудад сумын ЗДТГ-аас шилжиж ирсэн мөнгөн хөрөнгөнөөс урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалт, Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаалаар батлагдсан заавартай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж ажиллах

**5. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 33, зарлагын 7 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 17 шийдвэр, дараа жилийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, тайлан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай

мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.1."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:", 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" заалт болон "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**6. Ахмадын сангийн талаар**

Илрүүлэлт:

Рашаант сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах..." гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөг тааруулаагүй	1	29,712.9	1	29,712.9						
Үнэ төлбөргүй авсан бараа, материалыг давхардуулж орлогод авсан	1	2,971.9			1	2,971.9				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй.	1		1	-						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>32,684.8</b>	<b>2</b>	<b>29,712.9</b>	<b>1</b>	<b>2,971.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчсөн	1	600.0					1	600.0

Албан тушаалын цалингийн жишгийг нэмэгдүүлж тогтоосон.	1	1,052.1			1	1,052.1		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,652.1</b>			<b>1</b>	<b>1,052.1</b>	<b>2</b>	<b>600.0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Эм, эмнэлгийн хэрэгслэлийн шууд худалдан авалтын дүн шууд худалдан авах дээд хязгаараас давсан.	1	-			1	-		
Тайлант жилийн төсөвт орсон өөрчлөлтийг тусгаж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй, зарим зардлыг ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй.	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-
Бараа материалын үлдэгдэлд жилийн турш хөдөлгөөн хийгдээгүй, өмнөх оноос шилжиж ирсэн эмийн үлдэгдэлтэй байна.	1	446.6			1	446.6		
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>446.6</b>			<b>2</b>	<b>446.6</b>	<b>4</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 43/12270469/

Мөрөн сум

ХАА-2025/009/МӨР-ЭР ТЛ13

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саруулын албан тушаалын үндсэн цалинг буруу тогтоож 1,052,080 (нэг сая тавин хоёр мянга ная) төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан цалингийн сүлжээг мөрдөөгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан хаагчдын цалинг тогтоохдоо хүчин төгөлдөр мөрдөж буй цалингийн сүлжээг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Рашаант сумын Засаг дарга Э.Мягмарцогт, Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саруул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЗБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724070517



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарыг 25 өдөр

№ 42/19270469)

Мөрөн сум

ХВА. 2025/009/МӨ-СГА-ЛНБ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эмийн шууд худалдан авалтын дүн нь "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 24,836,107 (хорин дөрвөн сая найман зуун гучин зургаан мянга нэг зуун долоо) төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно." заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саруул, нягтлан бодогч Т.Болормаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724070476



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ 41/ААА ҮОМ69/

Мөрөн сум

ХАА-2025/009/НА-СГА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдлийг эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарлагдаагүй, эмчилгээнд хэрэглэх шаардлага гараагүй, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналт сул зэрэг шалтгаанаар тус байгууллагын бараа материалын дансны үлдэгдэлд 446,578 (дөрвөн зуун дөчин зургаан мянга таван зуун далан найм) төгрөгийн өмнөх оноос шилжиж ирсэн, бүтэн жилийн турш зарлагын хөдөлгөөн хийгдээгүй эм бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," заалтыг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалахгүй байх, эмийн үлдэгдэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, бараа материалын үлдэгдлийн эхэлж авснаа эхэлж зарлагдах аргыг тууштай мөрдөж ажиллах, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Рашаант сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Саруул, нягтлан бодогч Т.Болормаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

6724030478